



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/360

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дээвэр нь ашиглалтын шаардлага хангахгүй талаар мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн дүгнэлт гарсантай холбогдуулан засварын ажилд зориулан 9 789 100 /Есөн сая долоон зуун наян есөн мянга нэг зуу/ -н төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 9 789 100 төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.2-д “Эх хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ дэд хөтөлбөр” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 24-ний өдрийн
А/360 дугаар захирамжийн хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН РАШААНТ ӨРХИЙН ӨРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
БАРИЛГЫН ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ТООЦОО

/Төгрөгөөр/

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нийт
1	Хуулмал материалан дээвэр буулгах	227	м ²	9 789 100
2	Хуулмал материалан дээвэрт 2 үе хар цаас наах	227	м ²	
3	Дээврийн 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	227	м ²	
Ажилчдын цалин, тээвэр, машин механизм, НӨАТ багтсан.				
Нийт				9 789 100

-oOo-